



ОНОШЛУУР
НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

№ 2016/lab/01.01

2016 оны 06 дугаар сарын 27 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төв (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Сетунари ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 06 дугаар сарын 27 өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь Оношлуур, тэжээлт орчин, урвалж, химиин бодис худалдан авах 2016/lab/01 тоот тендер шалгаруулалт багц 1 “Оношлуур”-ыг (цаашид “бараа” гэх) 49,747,400.00 (Дөчин есөн сая долоон зуун дөчин долоон мянга дөрвөн зуун) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.

1.3 Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хоёр. Гэрээний бүрдэл

2 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 2.1.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 2.1.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 2.1.3 Тендер ба үнийн хуваарь;

- 2.1.4 Гэрээний тусгай нөхцөл;
 - 2.1.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 2.1.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 2.1.7 Санхүүжилтийн хуваарь.
- 2.2 Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.
- 2.3 Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Гурав. Нийлүүлэгчийн эрх үүрэг

- 3.1 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог гарсан тохиолдолд арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 3.2 Нийлүүлэгч нь бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу захиалагчид нийлүүлнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх үүрэг

- 4.1 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 4.2 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.
- 4.3 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Тав. Гэрээний үнэ, төлбөр хийх нөхцөл

- 5.1 49,747,400.00 (Дөчин есөн сая долоон зуун дөчин долоон мянга дөрвөн зуун) төгрөгийг улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 5.2 Захиалагч нь гэрээний үнийн дүнгийн 30%-ийг буюу 14,924,220.00 (Арван дөрвөн сая есөн зуун хорин дөрвөн мянга хоёр зуун хорин) төгрөгийг гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор багтаан нийлүүлэгчид нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлнэ.
- 5.3 Гэрээний бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааг хүлээлгэн өгснөөс хойш 15 хоногийн дотор захиалагч нь нийлүүлсэн тухайн барааны үлдэгдэл үнийн дүн болох 34,823,180.00 (Гучин дөрвөн сая найман зуун хорин гурван мянга нэг зуун наян) төгрөгийг нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.
- 5.4 Гэрээний үнийн дүнг төгрөгөөр тооцно.

Зургаа. Бараа нийлүүлэх хугацаа

- 6.1 Нийлүүлэгч нь хавсралтанд дурдсан барааг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 45 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэн өгнө.

6.2 Энэхүү гэрээний 5.2-д зааснаар урьдчилгаа төлбөрийг Захиалагч хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд шилжүүлсэн өдрөөс эхлэн 6.1 заалт дахь хугацаа өөрчлөгднө.

Долоо. Гэрээний хариуцлага

7.1 Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг энэхүү гэрээний 6.2-д заасан хугацаанаас хоцорч нийлүүлсэн тохиолдолд хоцорсон хоног тутамд нийлүүлж амжаагүй барааны үнийн дүнгийн 0,2%-тай тэнцэх торгуулийг ногдуулан Захиалагчид төлөх үүрэг хүлээнэ.

7.2 Захиалагч нь Нийлүүлэгчийн нийлүүлсэн барааны төлбөрийг 5.3-д заасан хугацаанаас хоцорч, шилжүүлээгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд төлөөгүй үнийн дүнгийн 0,2 %-тай тэнцэх алдангийг Нийлүүлэгч талд төлөх үүрэг хүлээнэ.

7.3 Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг Захиалагчид хүлээлгэн өгөхдөө бараа хүлээлгэн өгөх акт үйлдэж, Захиалагч нь хүлээн авснаа баталгаажуулна.


Найм. Бусад зүйл

8.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, тус бүр нэг хувь авч үлдэнэ.

8.2 Энэхүү гэрээ нь талууд эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт тооцно.

8.3 Гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн альваа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцэж шийлдвэрлэхийг урьтал болгох ба хэрэв тохиролцож чадахгүйд хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Чанар хяналт үнэлгээ дотоод аудитын албаны дарга
...../ Э.Тунгалаг /

Захиалаг: ЗӨСҮТ
Улаанбаатар хот, СХД, 20-р хороо,
Төрийн сан банк данс: 900020021
РД: 9092005
Утас: 70282859

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Сетунари” ХХК-ийн
Чанарын менежер
...../Ч.Оюун-Эрдэнэ/

Улаанбаатар хот, БГДүүрэг 5-р хороо, 10-р хороолол, Ард Аюушийн өргөн чөлөө 79
Худалдаа хөгжлийн банк данс: 499139296
РД: 5189845 ✓
Утас: 70177016, 86779676

Хянасан: ЗӨСҮТөвийн хуулийн зөвлөх  Б.Ариухантемер



2016/lab/01.01 тоот гэрээний хавсралт:

№	Оношлуур, урвалжийн нэр	ХЭМЖИХ НЭГЖ	ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН МЭДЭГДЭЛ	ТОО ХЭМЖЭЭ	НЭГЖИЙН ҮНЭ	НИЙТ ҮНЭ
1	Анти TBEV IgM ELISA	цомог	Euroimmun	2	518,000	1,036,000
2	Анти TBEV IgG ELISA	цомог	Euroimmun	3	474,000	1,422,000
3	IIFT Anti-TBE Virus IgM	цомог	Euroimmun	2	345,000	690,000
4	IIFT Anti-TBE Virus IgG	цомог	Euroimmun	3	345,000	1,035,000
5	Anti-Japanese encephalitis virus IgG ELISA	цомог	Euroimmun	2	474,000	948,000
6	Anti -Japanese encephalitis virus IgG IFA	цомог	Euroimmun	1	518,000	518,000
7	Anti- WNV IgM ELISA	цомог	Euroimmun	1	518,000	518,000
8	Anti -WNV IgG ELISA	цомог	Euroimmun	2	474,000	948,000
9	WNV IgG IIFA	цомог	Euroimmun	2	345,000	690,000
10	Anti - Dengue IgM ELISA	цомог	Diagnostic automation	1	354,000	354,000
11	Anti -Dengue IgG ELISA	цомог	Diagnostic automation	2	354,000	708,000
12	Crimean Congo fever virus IgG IFA	цомог	Euroimmun	2	560,000	1,120,000
13	Rickettsia spp IgG ELISA	цомог	Fuller lab	3	3,370,000	10,110,000
14	Rickettsia (RMSF)IFA IgM	цомог	Fuller lab	3	3,420,000	10,260,000

15	Rickettsia (RMSF) IFA IgG	цомог	Fuller lab	4	2,280,000	9,120,000
16	Anti-Borellia ELISA (IgM)	цомог	Euroimmun	1	474,000	474,000
17	Anti-Borellia plus VlsE ELISA (IgG)	цомог	Euroimmun	2	518,000	1,036,000
18	IIFT Mosaic:B.Afzelii/B.burgdorferi/B.garinii (IgG)	цомог	Euroimmun	2	421,000	842,000
19	IIFT Mosaic:B.Afzelii/B.burgdorferi/B.garinii (IgM)	цомог	Euroimmun	2	421,000	842,000
20	"Hantaviruses Mosaic1" (PUUV, SNV, DOBV, HTNV, SEOV, Saaremaa) IgG IFA	цомог	Euroimmun	1	1,395,000	1,395,000
21	Hanta virus Pool 1 "Euroasia" (HTNV, DOBV, PUUV) IgG ELISA	цомог	Euroimmun	1	516,200	516,200
22	Hanta virus Ag IFA (rodent)	цомог	Diagnostic automation USA	1	1,775,900	1,775,900
23	Anti-Toxoplasma gondii IgG IIFT	цомог	Euroimmun	1	161,800	161,800
24	Anti- Toxoplasma gondii ELISA (IgG)	цомог	Euroimmun	2	432,000	864,000
25	Cryptosporidium IgG ELISA	цомог	Diagnostic automation	1	1,062,000	1,062,000
26	Leishmania IgG IIFA	цомог	Euroimmun	1	271,000	271,000
27	Anti-Echinococcus-granulosus IIFT (IgG)	цомог	Euroimmun	2	271,000	542,000
28	B.anthracis Protective antigen Ag ELISA	цомог	Quick ELISA	1	488,500	488,500
Нийт үнэ						49,747,400